



УАГ
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

**“АВТО ЗАМЫН ТОНОГ
ТӨХӨӨРӨМЖИЙН ТҮРЭЭС”
ТӨХК-ИЙН 2017 ОНЫ
САНХҮҮГИЙН ТАЙЛАН**

**Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл
дараах хаягаар харилцана уу:**

Аудитын тайлан

Үндэсний Аудитын газар
САГ-ын захирал бөгөөд
тэргүүлэх аудитор
Ц. Наранчимэг
Утас: 261663

Хавсралт 1: Агуулга

Аудитын менежер: Г. Гүнжидмаа
Утас: 261628

Хавсралт 2: Менежментийн захидал

Аудитор: П. Амарсанаа
Утас: 261628

Хавсралт 3: Аудит хийгдсэн
санхүүгийн “тайлан

Засгийн газрын IV байр
Бага тойруу

Хавсралт 4: Аудитын хураангуй тайлан

Хавсралт 5: Зөрчлийн нэгтгэл

Улаанбаатар-46
Монгол улс
Цахим хаяг: www.audit.mn

Хавсралт 6: Асуудлын бүртгэл

“Атланта баланс аудит” ХХК
Захирал: Г.Жаргал
Утас: 99105629

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
**ХЯЗГААРЛАЛТАЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

АГУУЛГА

1	Аудитын гэрчилгээ	
2	Аудитын тайлан	
2.1	Оршил	1
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	1
2.3	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль эрх зүйн орчин	2
2.4	Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим, түүний үр дүн	2
2.5	Дотоод хяналт	3
2.6	Орлого зардлын гүйцэтгэл, түүний талаархи мэдээлэл	3
2.7	Шилэн дансны мэдээлэл	3
2.8	Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар	3
2.9	Аудитаар илрүүлсэн алдаа. зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл	4
2.10	Анхаарал татахуйц бусад асуудал	4
2.11	Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд	4
2.12	Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл	5
2.13	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	5
2.14	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	5
2.15	Санал, дүгнэлтийн хэлбэр үндэслэл	5
3	Менежментийн захидал	6
3.1	Бараа материалын талаар	7
3.2	Өглөгийн талаар	8
3.3	Үндсэн хөрөнгийн талаар	9
4	Аудит хийгдсэн санхүүгийн тайлан	10
4.1	Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан	10
4.2	Аудит хийгдсэн орлогын дэлгэрэнгүй тайлан	12
4.3	Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө / өмчийн өөрчлөлтийн тайлан/	14
4.4	Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан	15
4.5	Аудит хийгдсэн зардлын төлөвлөгөө ба гүйцэтгэл	17

2. АУДИТЫН ТАЙЛАН

2.1 Оршил

“Авто замын тоног төхөөрөмжийн түрээс” ТӨХК-ийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн аудитын тайланг “Авто замын тоног төхөөрөм-

жийн түрээс” ТӨХК-ийн захирал Г.Гантулга танд танилцуулж байна.

Энэхүү тайланд танай байгууллагын санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, залруулаагүй материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудит хийсэн санхүүгийн тайлан, батлагдсан төлөвлөгөөний гүйцэтгэл, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Менежментийн захидалд үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн аудитын журам, гарын авлагад дурдсан аудитын төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналын үе шатны ажлыг гүйцэтгэж, баримтжуулсан бөгөөд аудитад баримталсан стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон болно.


2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.5, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Авто замын тоног төхөөрөмжийн түрээс” ТӨХК-ийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Аудитыг Төрийн аудитын тухай, Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандарт, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

“Авто замын тоног төхөөрөмжийн түрээс” ТӨХК-ийн 2017 оны санхүүгийн тайлан, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /НББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа, НББОУС, түүнд нийцүүлэн гаргасан нягтлан бодох бүртгэлийн бодлого, батлагдсан заавар журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.



Харин тухайн санхүүгийн тайлан, дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2018 оны 01 дүгээр сарын 23-ны өдрөөс 2018 оны 03 дугаар сарын 12-ны хооронд хийж, аудитын тайланг 2018 оны 3 дугаар сарын 15-нд эцэслэн баталгаажуулж, удирдлагад хүргүүлэхээр төлөвлөн, “Атланта баланс аудит” ХХК-ийн чанарын хяналтыг ахлах аудитор Б.Баярмаа, аудитор А.Дэнсмаа, туслах аудитор Т.Ундармаа нар хэрэгжүүлэв.

“Авто замын тоног төхөөрөмжийн түрээс” ТӨХК-ийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг, 2018 оны 2 дугаар сарын 12-ны өдөр “Атланта баланс аудит” ХХК-д ирүүлсэн байна.

2.3 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

“Авто замын тоног төхөөрөмжийн түрээс” ТӨХК нь Зам барилгын технологийн зориулалт бүхий машин техникийг түрээслэхээс гадна тусгай зөвшөөрлийн дагуу авто зам барих, засварлах, авто замын барилга угсралт болон засвар арчлалтын ажил хийж гүйцэтгэж байна.

“Авто замын тоног төхөөрөмжийн түрээс” ТӨХК нь Авто замын тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Шилэн дансны тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Хөдөлмөрийн тухай, Нийгмийн даатгалын тухай хуулиуд, болон бусад холбогдох хууль, тогтоол, шийдвэрийн хүрээнд үйл ажиллагаа явуулж байна.

2.4 Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн


Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, НББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

“Авто замын тоног төхөөрөмжийн түрээс” ТӨХК-ийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд дүгнэлт өгөх, үүднээс санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа.

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж 7 дансанд аудитын нарийвчилсан горим, сорил 19-ийг гүйцэтгэв.

“Авто замын тоног төхөөрөмжийн түрээс” ТӨХК-ийн санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулгын аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ.

“Авто замын тоног төхөөрөмжийн түрээс” ТӨХК нь санхүүгийн аудитыг байгууллага нь санхүүгийн үйл ажиллагааг санхүүгийн “Импро-системс” ХХК-ийн



“Авто замын тоног төхөөрөмжийн түрээс” ТӨХК-ийн 2017 оны санхүүгийн тайлангийн аудит

“МАКС” санхүүгийн програмаар боловсруулан санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу санхүүгийн тайлангаа гаргасан байна.

2.5 Дотоод хяналт

Санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм. “Авто замын тоног төхөөрөмжийн түрээс” ТӨХК-ийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үед бага гэж тооцсон ба дахин хянахад дотоод хяналт хэвийн байна. Байгууллагын дотоод хяналтыг сайжруулж өмч хамгаалах байнгын комисс, техникийн комисс байгуулж ажиллах журмыг баталсан.

2.6 Орлогын гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

“Авто замын тоног төхөөрөмжийн түрээс” ТӨХК нь 2017 онд үндсэн үйл ажиллагааны орлого 646.0 сая төгрөгөөр төлөвлөснөөс, гүйцэтгэлээр 499.9 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 146.1 сая төгрөгөөр буюу 22.6 хувиар тасарсан байна. Үйл ажиллагааны зардал 192.8 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 185.6 сая төгрөг зарцуулж, 7.2 сая төгрөгийн хэмнэлттэй ажилласан байна. 2017 онд гражийн барилгад 6.6 сая төгрөгийн их засвар хийж капиталжуулсан.

2.7 Шилэн дансны мэдээлэл

“Шилэн дансны тухай” хуулийн дагуу төсвийн болон улс, орон нутгийн өмчийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах зорилгоор удирдлагын шийдвэр, үйл ажиллагаа ил тод, нээлттэй, ойлгомжтой байх түүнд олон нийт хяналт тавих мэдээллийн тогтолцоог хуулийн дагуу хангасан байх талаар судалж үзэхэд Shilendans.gov.mn сайтад Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, Хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээлэл, концессийн мэдээлэл, Худалдан авах үйл ажиллагааны тайлан зэрэг 4 мэдээлэл оруулахаас 2017 онд мэдээлэл оруулаагүй байна.

2.8 Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 2 чиглэлээр эрсдэл тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд 7 дансанд нийт 19 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв. Хэрэгжүүлсэн горим сорилын үр дүнг гүйцэтгэлийн үе шатны төлөвлөсөн горим, сорилуудыг хэрэгжүүлж, үр дүнг аудитын чиглэл тус бүрээр баримтжуулах гэсэн үе шатны ажилд хамааруулан ТАБ-СТА-В-3 маягтаар данс тус бүрээр баримтжуулсан болно.



2.9 Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл

Аудитын явцад материаллаг хэмжээний дараах алдаа илэрсэн байна. Үүнд:

1. Бараа материалын дансанд 68.5 сая төгрөгийн ашиглалтанд байгаа бага үнэтэй түргэн элэгдэх зүйлсийг бүртгэсэн байна.

Шийдвэрлэсэн нь: Менежментийн захидлаар зөвлөмж өгөв.

2. “Насны зам” ХХК, “Хотын зам” ХХК, “Хэрэм зам” ХХК, “Эрдэнэ суварга” ХХК, “Баганат өргөө” ХХК-иудын авлага 83.0 сая төгрөг, Хувь хүмүүсээс авах 2.6 сая төгрөгийн хугацаа хэтэрсэн авлага нь “Нягтлан бодох бүртгэлийн тухай” хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.4-д “Эд хөрөнгийн тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тогтоосон хугацаанд тооцоо нийлж, үлдэгдлийг баталгаажуулах” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөв.

3. “Тэвхэн” ХХК-ийн 2.4 сая төгрөг, “Эвт уул” ХХК-ийн 3.0 сая төгрөгийн өглөг, урт хугацаат зээлийн өрийн үлдэгдэл 1.8 сая төгрөг (ханшийн зөрүү)-өөр илүү тайлагнасан нь “Нягтлан бодох бүртгэлийн тухай” хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.4-д “Эд хөрөнгийн тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тогтоосон хугацаанд тооцоо нийлж, үлдэгдлийг баталгаажуулах” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Менежментийн захидлаар зөвлөмж өгөв.

4. Барилга байгууламжийн ашиглалтын хугацааг 30 жилээр элэгдүүлж, конторын барилга, гражийн барилгын элэгдлийн зардлыг 8.7 сая төгрөгөөр илүү тооцоолсон материаллаг бус алдаа залруулагдаагүй болно.


Шийдвэрлэсэн нь: Менежментийн захидлаар зөвлөмж өгөв.

2.10 Анхаарал татахуйц бусад чухал асуудал

“Авто замын тоног төхөөрөмжийн түрээс” ТӨХК нь Засгийн газрын 2018 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн 09 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Татан буулгах төрийн өмчит хуулийн этгээдийн жагсаалт”-д тус компаний үйл ажиллагааг зогсоож, татан буулгахаар шийдвэрлэсэн байна.

2.11 Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд

“Авто замын тоног төхөөрөмжийн түрээс” ТӨХК-ийн үйл ажиллагааг зогсоох шийдвэр гарсантай холбогдуулан найдваргүй өглөг, авлага, бараа материалд үлдэгдэлтэй байгаа багаж хэрэгсэл, эд зүйлсийн бүртгэлийг дахин авч үзэх хэрэггүй.



2.12 Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл

“Авто замын тоног төхөөрөмжийн түрээс” ТӨХК-ийн 2017 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар бараа материалын дансанд 68.5 сая төгрөгийн ашиглалтанд байгаа бага үнэтэй түргэн элэгдэх зүйлсийг бүртгэсэн, тооцоо нийлж баталгаажуулаагүй 83.0 сая төгрөгийн авлага төгрөг, 7.2 сая төгрөгийн өглөг, мөн 8.7 сая төгрөгөөр үндсэн хөрөнгийн элэгдлийг илүү тооцоолсон зэрэг зөрчил илэрсэн.

2.13 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

“Авто замын тоног төхөөрөмжийн түрээс” ТӨХК-ийн 2016 оны санхүүгийн тайланд “Баян ташаагийн эх аудит” ХХК аудит хийж 5 зөвлөмж өгсөн байна.

Зөвлөмжийн дагуу өглөг, авлагыг барагдуулах талаар ажиллаж 40 гаруй хувийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулсан ба өмнөх үеийн цалин, татварын өглөгүүдийг 51.2 сая төгрөгөөр бууруулж, борлуулалтын орлого урд оныхоос 330.9 сая төгрөгөөр өссөн байна.

2.14 Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар:

Төлөвлөлтийн үе шатанд ТАБ-СТА-А-1 маягтыг ашиглан материаллаг түвшинг тогтоохдоо борлуулалтын орлогыг суурь үзүүлэлт болгон сонгосон бөгөөд 2 хувиар буюу 18.0 сая төгрөгөөр тооцох нь зүйтэй гэж үзсэн. Гүйцэтгэлийн үе шатанд шинж чанарын болон орчин нөхцлийн хувьд материаллаг байдал илэрсэнгүй.

2.15 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

“Авто замын тоног төхөөрөмжийн түрээс” ТӨХК-ийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайланд авлага, өглөгийн хугацаа хэтэрсэн, ашиглалтанд байгаа багаж хэрэгсэл, эд зүйлсийг бараа материалд бүртгэж байсан зэрэг зөрчлүүд нь өмнөх онуудад үүссэн байгаагийн хувьд Хязгаарлалттай санал дүгнэлт өгөх саналтай байна.



3. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Үндэсний аудитын газар аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгчид зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүүгийн хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг билээ.

Энэхүү менежментийн захидлын агуулга Аудитын олон улсын стандарт болон аудитын горимоос урган гарсан болно. Санхүүгийн тайлангийн талаар санал дүгнэлт гаргахад бидний горим зориулагдсан.

Энэ нь “Авто замын тоног төхөөрөмжийн түрээс” ТӨХК-ийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан санхүүгийн ажилтнуудад талархал илэрхийлье.

Менежментийн захидалд дурдсан зөвлөмжүүд цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг ач холбогдлынх нь дарааллаар эрэмбэлэн дор нэгтгэн харуулав.



3.1 Бараа материалын талаар

Тэргүүлэх ач холбогдол №1

ҮАГ-ын ажиглалт

Бараа материалын дансанд 68.5 сая төгрөгийн ашиглалтанд байгаа бага үнэтэй түргэн элэгдэх зүйлсийг бүртгэсэн нь Сангийн сайдын 2014 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 249 дүгээр тушаалаар батлагдсан “Аж ахуй нэгжийн нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-тай нийцэхгүй байна.

Эрсдэлүүд

Санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх эрсдэл

ҮАГ-ын зөвлөмж

Сангийн сайдын 2014 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 249 дүгээр тушаалаар батлагдсан “Аж ахуй нэгжийн нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ыг мөрдөж ажиллах зөвлөмж өгч байна.

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлнэ.

Төсвийн захирагчийн хариу

2018 оны 03 дугаар сарын 13-ны өдрийн №04 тоот албан бичгээр ирсэн.



3.2 Өглөгийн талаар

Тэргүүлэх ач холбогдол №1

ҮАГ-ын ажиглалт

“Тэвхэн” ХХК-ийн 2.4 сая төгрөг, “Эвт уул” ХХК-ийн 3.0 сая төгрөгийн өглөг, урт хугацаат зээлийн өрийн үлдэгдэл 1.8 сая төгрөг (ханшийн зөрүү)-өөр илүү тайлагнасан нь “Нягтлан бодох бүртгэлийн тухай” хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.4-д “Эд хөрөнгийн тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тогтоосон хугацаанд тооцоо нийлж, үлдэгдлийг баталгаажуулах” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Эрсдэлүүд

Найдваргүй өглөг үүсэх эрсдэл

ҮАГ-ын зөвлөмж

“Нягтлан бодох бүртгэлийн тухай” хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.4-д “Эд хөрөнгийн тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тогтоосон хугацаанд тооцоо нийлж, үлдэгдлийг баталгаажуулах” гэсэн заалтыг мөрдөж ажиллах зөвлөмж өгч байна.

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлнэ.

Төсвийн захирагчийн хариу

2018 оны 03 дугаар сарын 13-ны өдрийн №04 тоот албан бичгээр ирсэн.

3.3 Үндсэн хөрөнгийн талаар

Тэргүүлэх ач холбогдол №1

ҮАГ-ын ажиглалт

Барилга байгууламжийн ашиглалтын хугацааг 30 жилээр элэгдүүлж, конторын барилга, гражийн барилгын элэгдлийн зардлыг 8.7 сая төгрөгөөр илүү тооцоолсон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.2-д “Батлагдсан маягт, зааврын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайланг гаргах, аж ахуйн нэгж байгууллагын удирдлага болон санхүүгийн тайлан хэрэглэгчдийг цаг хугацаанд нь үнэн, зөв мэдээллээр хангах ажлыг зохион байгуулах” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Эрсдэлүүд

Үндсэн хөрөнгийн үлдэгдэл өртөг буруу тооцоолох эрсдэл

ҮАГ-ын зөвлөмж

“Нягтлан бодох бүртгэлийн тухай” хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.2-д “Батлагдсан маягт, зааврын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайланг гаргах, аж ахуйн нэгж байгууллагын удирдлага болон санхүүгийн тайлан хэрэглэгчдийг цаг хугацаанд нь үнэн, зөв мэдээллээр хангах ажлыг зохион байгуулах” гэсэн заалтыг мөрдөж ажиллах зөвлөмж өгч байна.

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлнэ.

Төсвийн захирагчийн хариу

2018 оны 03 дугаар сарын 13-ны өдрийн №04 тоот албан бичгээр

01


ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ХЯЗГААРЛАЛТАЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

4.1 АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН


Авто замын тоног төхөөрөмжийн түрээс ТӨХК /төгрөг/ 2017 оны 12 сарын 31 өдөр

Балансын зүйл	2016 оны 12 дугаар сарын 31	2017 оны 12 дугаар сарын 31
Хөрөнгө		
Эргэлтийн хөрөнгө		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	697,190.67	2,001,565.85
Дансны авлага	229,742,211.68	202,656,021.64
Татвар, НДШ-ийн авлага		
Бусад авлага	2,665,000.00	6,125,000.00
Бусад санхүүгийн хөрөнгө		
Бараа материал	185,012,691.26	125,273,720.54
Урьдчилж төлсөн зардал/тооцоо		
Бусад эргэлтийн хөрөнгө		
Эргэлтийн бус хөрөнгө /борлуулах бүлэг/		
Эргэлтийн хөрөнгийн дүн	418,117,093.61	336,056,308.03
Эргэлтийн бус хөрөнгө		
Үндсэн хөрөнгө	643,113,898.63	563,411,180.42
Биет бус хөрөнгө	2,628,787.91	1,325,757.54
Биологийн хөрөнгө		
Урт хугацаат хөрөнгө оруулалт		
Хайгуул ба үнэлгээний хөрөнгө		
Хойшлогдсон татварын хөрөнгө		
Хөдлөх хөрөнгө		
Бусад эргэлтийн бус хөрөнгө		
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	645,742,686.54	564,736,937.96
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	1,063,859,780.15	900,793,245.99
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
Өр төлбөр		
Богино хугацаат өр төлбөр		
Дансны өглөг	332,695,199.60	312,220,774.33



“Авто замын тоног төхөөрөмжийн түрээс” ТӨХК-ийн 2017 оны санхүүгийн тайлангийн аудит


Цалингийн өглөг	88,599,686.35	117,538,087.65
Татварын өглөг	102,780,147.20	119,185,057.95
НДШ-ийн өглөг	65,985,630.07	50,092,539.14
Богино хугацаат зээл	39,740,886.83	24,250,206.14
Хүүний өглөг		
Ногдол ашгийн өглөг		
Урьдчилж орсон орлого		
Нөөц /өр төлбөр/		
Бусад богино хугацаат өр төлбөр	3,379,529.18	118,786.85
Эргэлтийн бус хөрөнгө/борлуулах бүлэг		
Богино хугацаат өр төлбөрийн дүн	633,181,079.23	623,405,452.06
Урт хугацаат өр төлбөр		
Урт хугацаат зээл		
Нөөц /өр төлбөр/		
Хойшлогдсон татварын өр		
Бусад урт хугацаат өр төлбөр	9,698,666.79	9,042,659.79
Урт хугацаат өр төлбөрийн дүн	9,698,666.79	9,042,659.79
Өр төлбөрийн нийт дүн	642,879,746.02	632,448,111.85
Эздийн өмч		
Өмч: төрийн	2,075,698,548.36	2,075,698,548.36
хувийн		
хувьцаат		
Халаасны хувьцаа		
Нэмж төлөгдсөн капитал		
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	182,081,400.00	182,081,400.00
Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц		
Эздийн өмчийн бусад хэсэг		
Хуримтлагдсан ашиг	(1,836,799,914.23)	(1,989,434,814.22)
Эздийн өмчийн дүн	420,980,034.13	268,345,134.14
ДҮН	1,063,859,780.15	900,793,245.99



ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

Авто замын тоног төхөөрөмжийн түрээс ТӨХК /төгрөг/ 2017 оны 12 сарын 31 өдөр

Д/Д	Үзүүлэлтийн нэр	2016 оны 12 дугаар сарын 31	2017 оны 12 дугаар сарын 31
1	Борлуулалтын орлого (Цэвэр орлого)	169,040,108.20	499,924,064.53
2	Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	909,710,027.66	434,032,944.18
3	Нийт ашиг (алдагдал)	(740,669,919.46)	65,891,120.35
4	Түрээсийн орлого		
5	Хүүний орлого		3,852.75
6	Ногдол ашгийн тооцоо		
7	Эрхийн шимтгэлийн орлого		
8	Бусад орлого		
9	Борлуулалт, маркетингийн зардал		
10	Ерөнхий ба удирдлагын зардал	183,597,477.95	185,639,627.08
11	Санхүүгийн зардал		
12	Бусад зардал		1,694,527.28
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)		
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
15	биет бус хөрөнгө данснаас хассаны олз		
16	хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз		
17	Бусад ашиг (алдагдал)		
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(924,267,397.41)	(121,439,181.26)
19	Орлогын татварын зардал		
20	Ердийн үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	(924,267,397.41)	(121,439,181.26)
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)		
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	(924,267,397.41)	(121,439,181.26)
23	Бусад дэлгэрэнгүй орлого		
	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү		
	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		




	Бусад олз (гарз)		
24	Нийт дэлгэрэнгүй орлогын дүн	(924,267,397.41)	(121,439,181.26)
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг		

ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

Авто замын тоног төхөөрөмжийн түрээс ТӨХК /төгрөг/

2017 оны 12 сарын 31 өдөр


№	ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2015 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	2,069,637,548.36	182,081,400.0	(912,532,516.82)	1,339,186,431.54
2	НББ-ын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга			(270,909,517.15)	
3	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)			(653,357,880.26)	(924,267,397.41)
4	Бусад дэлгэрэнгүй орлого				
5	Өмчид гарсан өөрчлөлт	6,061,000.0			6,061,000.0
6	2016 оны 12 -р сарын 31-ний үлдэгдэл	2,075,698,548.36	182,081,400.0	(1,836,799,914.23)	420,980,034.13
7	НББ-ын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга				
8	Залруулсан үлдэгдэл				
9	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)			(152,634,899.99)	(152,634,899.99)
10	Бусад дэлгэрэнгүй орлого				
11	Өмчид гарсан өөрчлөлт				
12	Зарласан ногдол ашиг				
13	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн				
14	2017 оны 12 -р сарын 31 -ний үлдэгдэл	2,075,698,548.36	182,081,400.0	(1,989,434,814.22)	268,345,134.14



МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Авто замын тоног төхөөрөмжийн түрээс ТӨХК /төгрөг/ 2017 оны 12 сарын 31 өдөр

Д/Д	Үзүүлэлтийн нэр	2016 оны 12 дугаар сарын 31	2017 оны 12 дугаар сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	426,375,938.00	505,066,480.63
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	2,605,000.00	505,066,480.63
	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого		
	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө		
	Буцаан авсан албан татвар		
	Татаас, санхүүжилтийн орлого		
	Бусад мөнгөн орлого	423,770,938.00	
1.2	Мөнгөн зарлагын дүн	466,171,761.83	503,765,958.20
	Ажиллагчдад төлсөн	57,461,403.00	127,805,711.26
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн		56,928,306.00
	Бараа материал худалдан авахад төлсөн	45,846,309.29	10,858,669.60
	Ашиглалтын зардал төлсөн	5,277,916.00	5,765,017.00
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	34,291,984.62	249,370,258.75
	Хүүний төлбөрт төлсөн	5,677,211.61	14,609,319.31
	Татварын байгууллагад төлсөн	1,873,020.00	24,218,089.00
	Даатгалын байгууллагад төлсөн	252,000.00	144,000.00
	Бусад мөнгөн зарлага	315,491,917.31	14,066,587.28
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(39,795,823.83)	1,300,522.43
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн		3,852.75
	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого		
	Биет бус хөрөнгө борлуулсны орлого		
	Хөрөнгө оруулалт борлуулсны орлого		
	Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого		



	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт		
	Хүлээн авсан хүүний орлого		3,852.75
	Хүлээн авсан ногдол ашиг		
2.2	Мөнгөн зарлагын дүн		
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн		
	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа		
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ		3,852.75
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн	58,000,000.00	17,480,000.00
	Зээл авсан өрийг үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	58,000,000.00	17,480,000.00
	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
	Төрөл бүрийн хандив		
3.2	Мөнгөн зарлагын дүн	18,259,113.17	17,480,000.00
	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	18,259,113.17	17,480,000.00
	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн		
	Хүү болон урамшууллын орлого		
	Төлсөн ногдол ашиг		
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	39,740,886.83	
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(54,937.00)	1,304,375.18
5	Мөнгө, ба түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	752,127.67	697,190.67
6	Мөнгө, ба түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	697,190.67	2,001,565.85

АУДИТ ХИЙГДСЭН ЗАРДЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ БА ГҮЙЦЭТГЭЛ

Авто замын тоног төхөөрөмжийн түрээс ТӨХК / сая.төг/

2017 оны 12 сарын 31 өдөр

ТГ-ийн тайлан- гийн Код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	2017 он				Хувь
			Анх батлагд сан	Тодотгосон төсөв /2/	Гүйцэтгэл	Зөрүү	
А	Б	1	2	3	4	5	
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1 093,3	645,3	0,0	621,4	-23,9	96,3
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1 093,3	645,3	0,0	621,4	-23,9	96,3
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1 093,3	645,3	0,0	621,4	-23,9	96,3
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	138,5	209,5		156,7	-52,8	74,8
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	29,1	23,0		17,2	-5,8	74,8
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	8,0	10,3		6,4	-3,9	62,2
2104	Хангамж, бараа материалын зардал	153,8	118,5		95,0	-23,5	80,2
2105	Нормативт зардал	703,3	230,6		292,3	61,7	126,8
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		2,2		1,0	-1,1	47,4
2107	Томилолт, зочны зардал	6,8	3,5		8,0	4,6	231,0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	53,8	47,7	0,0	44,7	-3,0	93,7
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	49,3	41,0		38,9	-2,1	94,9
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	4,5	4,5		4,5	0,0	100,0
210803	Даатгалын үйлчилгээ		2,2		0,1	-2,1	6,4
210804	Тээврийн хэрэгслийн татвар				0,4	0,4	
210807	Газрын төлбөр				0,7	0,7	
210808	Банк, СБ-ын үйлчилгээний хураамж				0,0	0,0	
	АЖИЛЛАГСДЫН ТОО	0,0	20	0,0	20	0	100,0
	Удирдах ажилтан		4		4	0	100,0
	Гүйцэтгэх ажилтан		11		11	0	100,0
	Үйлчлэх ажилтан		5		5	0	100,0
	Гэрээт ажилтан						

